

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ 2017 ОНЫ 01 ДҮГЭЭР
САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2017.01.30

Нэг. Ерөнхий мэдээлэл

Орон тоо: Тус алба нь бүтэц орон тооны хувьд албаны дарга улсын ахлах байцаагч 1, улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч, нягтлан бодогч 1, улсын байцаагч нярав, бичиг хэрэг 1, улсын байцаагч 1 орон тоотойгоор ажиллаж байна.

Ил тод байдлын хүрээнд: Vulgan gov.mn вэб сайтад хяналт шалгалтын график, 2016 оны тайланг байршуулсан ба sankhuu audit би нүүр номонд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Сангийн сайдын 2017 оны 13 дугаар тушаал, хяналт шалгалтын график мэдээлсэн ба ABLE-ээр 16 сум 1 тосгонд 2016 онд шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөвлөмж, шилэн дансанд мэдээлэл байршуулсан байдлын албан бичгийг хүргүүлэв.

Байгууллагын мэдээллийн самбарт холбогдох хууль тогтоомж, төсвийн хуваарь, сарын мэдээг байршуулсан болно.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

Орон нутгийн төр захиргааны байгууллагын шийдвэр гаргуулсан байдал: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал, 2016 оны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил цаашид анхаарах асуудлуудаар мэдээлэл хийсэн ба Засаг даргын Зөвлөлийн хурлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал, Сум хөгжүүлэх сангийн зээлийн зориулалт үлдэгдэл, хугацаа хэтрэлтийн талаар мэдээлэл хийлээ.

Хууль тогтоомжийг хангуулахтай холбоотойгоор аймаг орон нутгийн хэмжээнд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын төсөл боловсруулан батлуулав.

Мөн аймгийн Засаг даргын Захирамжийн төсөл боловсруулаад байна.

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийн байдлын судалгаа гарган аймгийн Засаг даргын 01/149 тоот албан бичгийг сумдад хүргүүлэв.

Авсан арга хэмжээ: 2017 онд хяналт шалгалт хийх хяналтын график батлуулав. Зөрчлийн ангиллын судалгааг сүүлийн 3 жилээр нэгтгэн Санхүү төрийн сангийн хэлтэст өгөв.

Бүх сумдад 2016 онд илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөвлөмж, Шилэн дансны нэгдсэн вэб сайтад мэдээлэл байршуулсан байдалд дүгнэлт хийх тухай албан бичиг хүргүүлэв.

Сумдын удирдах ажилтнуудад, Тамгын газрын дарга нар, санхүүгийн албаны дарга нарт 2016 онд хяналт шалгалтаар илэрсэн зөрчил цаашид анхаарах асуудлууд, Шилэн дансны 2016 оны тайлан, цалин хөлстэй холбоотой дүрэм журмын хэрэгжилт, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, зориулалтын байдлаар мэдээлэл хийсэн давхардсан тоогоор 80 гаруй хүн хамрагдсан.

Гурав. Төсөв санхүүгийн үйл ажиллагаа

2016 оны санхүүгийн тайлан баланс гаргаж аймгийн Аудитын газарт өгөв. Шилэн дансны нэгдсэн вэб сайтад 10 мэдээлэл мэдээлэв.

Цалин 5762.5 мянган төгрөг, хоол унааны хөнгөлөлт 150,0 мянган төгрөг, ЭМНДШ 614,7 мянган төгрөг, тээвэр шатахуун 150.0 мянган төгрөг, албан томилолт 300,5 мянган төгрөг, бичиг хэрэг 4,5 мянган төгрөг нийт 6982,2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Дөрөв. Бусад мэдээлэл

2016 оны тушаал, хариутай болон илгээсэн, ирсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлт, хяналт шалгалтын удирдамж, хяналт шалгалтын танилцуулга, улсын байцаагчийн акт, улсын байцаагчийн албан шаардлагын бүртгэл зэргийг архивлав.

7 хоногийн төлөвлөгөө, шуурхай мэдээг гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст, “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ТЗУХ-т, “Эрх зүйн мэдээллийг иргэн бүрт” аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт гарган Хууль эрх зүйн хэлтэст тус тус өгөв.

ШШГА-тай Хишиг-Өндөр сумын Сум дундын эмнэлгийн нягтлан бодогч асан Мөнх-Эрдэнийн 5577,4 мянган төгрөгийн төлбөр барагдуулах гэрээ байгуулав.

Захиргааны хэргийн Шүүх, Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2015, 2016 онуудад хууль бус шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын судалгаа гаргуулан авав.

Ажилтнууд ХАСХОМ-ыг гарган хууль эрх зүйн хэлтэст баталгааны хуудсаар өгөв. Албаны дарга цаг үеийн ажлаар Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдад ажиллав. Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд 5 ажилтан оролцов.

Малчдад туслах аяны хүрээнд ажилтан бүр 10,0 мянган төгрөг, нийт 50,0 мянган төгрөг хандивлав.

Ирсэн албан бичиг 25, явуулсан албан бичиг 13 байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

Б.БАТТУЛГА